

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 4 дүгээр сарын
21-ний өдөр

Улаанбаатар
хот

Дугаар 64

ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

/“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, хөтөлбөрийн
Зөвлөлийн бүрэлдэхүүн/

Монгол Улсын малын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх ажлыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтын, уг хөтөлбөрийн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг Хөтөлбөрийн зөвлөлд тайлагнаж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт мэдээлж байхыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэнд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН
САЙД

Ж.НАРАНЦАЦРАЛТ
Ч.СОДНОМЦЭРЭН

“МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг.Монгол Улсын мал сүргийн эрүүл мэндийн өнөөгийн байдал

1.Манай улсад Мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын “А” ангиллын гоц халдварт өвчнүүд сүүлийн 20 гаруй жил илрээгүй байна. Иймд манай мал сүрэг ихэнх гоц халдварт өвчний эсрэг өвөрмөц хамгаалалтын дархлаагүй болж байна. Гадаад худалдаа, аялал, жуулчлал, иргэдийн зорчих хөдөлгөөн өргөжиж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд гадаадаас мал, амьтан, мах, махан бүтээгдэхүүн, түүхий эд импортлох нь ихэслээ. Энэ нь хилийн чанадаас мал, амьтны гоц халдварт өвчнүүд орж ирэх, тархан дэлгэрэх нөхцөлийг эрм нэмэгдүүлж байна.

Малын халдварт, паразиттах өвчлөлийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна. Тухайлбал, мал сүрэгт сүүлийн жилүүдэд цусан халдвар, бруцеллэз, галзуу, сүрьеэ, адууны халдварт цус багасах өвчний гаралт 1.2-19.2 дахин өсч, халдварт өвчнөөр хорогдсон малын тоо нийт хорогдлын 30 хувийг эзэлж байна. Малаас хүнд халдварладаг бруцеллэз, сүрьеэ, ям, лейкоз зэрэг өвчнийг оношлох шинжилгээг зохих ёсоор хийхгүй байгаагаас эдгээр өвчнийг хянаж чадахгүй байна. Судалгаанаас үзэхэд манай улсын хэмжээнд үхэр, тэмээ, бог малын бруцеллэз бүх сумын 11-43 хувийг хамарсан нь өргөн тархалттай байгааг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд Хөвсгөл, Завхан, Төв, Өвөрхангай зэрэг аймаг, Улаанбаатар хотын нутагт малын боом, галзуу өвчний гаралт эрс нэмэгдэж, тархалтын хүрээ тэлж шинээр голомтууд бүртгэгдэж байна.

Хоёр.Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

2.Монгол Улсын Үнэдсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг багасгах, хүн амын физиологийн хэрэгцээг хангахуйц амин дэм, уураг, бичил махбодоор баялаг хоол, хүнсээр хангах зорилтыг хэрэгжүүлэхэд мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, малаас хүн дамжин халдварладаг элдэв өвчнөөс эрүүлжүүлэх нь шийдвэрлэх ач холбогдолтой байна. Монгол Улсын эпизотологийн байдал тайван бус, ялангуяа малаас хүнд адмжин халварладаг “зоонатропонози” өвчин манай орны мал сүрэгт ихээхэн тархсан нь эгээр өвчинтэй тэмцэх, эрүүлжүүлэх арга хэмжээг төр, засгаас зориуд анхаарч урт хугацааны зорилтот хөтөлбөртэй, дэс дараалалтайгаар хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэнээр тус байгууллагаас тавьж байгаа шаардлагуудыг хангаж, өөрийн орны мал сүрэгт тархсан халдварт өвчнийг бүртгэж, тэдгээрийн голомтыг тогтоон хяналтад авч түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг шинжлэх ухааны батлагдсан арга зүйн дагуу хэрэгжүүлэхийн зэрэгцээ бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлын магадлан шинжилгээ, баталгаажуулалтыг олон улсын шаардлагын түвшинд аль болохоор ойртуулах хэрэгтэй байна.

Мал, амьтан, бүтээгдэхүүний олон улсын худалдаанд үндэсний мал эмнэлгийн байгууллагаар үнэн зөв баталгаажуулалт хийдэг болгохын тулд Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын үндэсний мал эмнэлгийн албыг магадлан итгэмжлэл олгодог тогтолцоонд дэлхий нийтээрээ шилжихээр бэлтгэж байгаа энэ үед манай улс өөрийн үндэсний мал эмнэлгийн тогтолцоогоо урьдчилан бэлтгэх зайлшгүй шаарлагатай юм.

Сүүлийн үед мал, мах экспортлох сонирхол өсч байна. Гэтэл малын өвчлөлийн байдал, мал, амьтан, бүтээгдэхүн, түүхий эд ариун цэврийн хяналт шинжилгээ хийгдэхгүй, мал эмнэлгийн байгууллага, мэргэжилтний мэдлэг, нэр хүнд ч сайнгүй байна. Өнөө үе олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мал эмнэлгийн байгууллага, өндөр мэдлэг, ур чадвартай малын эмч нарын хэрэгцээ шаардлага улам бүр өсч байна.

Гурав.Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.Мал сүрэг, аж ахуйн зориулалтаар үржүүлж буй амьтдын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх үндсэн дээр Монгол орон Мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын “А” ангиллын гоц халдварт өвчнүүдээс тайван байгааг хадгалан бататгах, нийгэм, эдийн засгийн үлэмж хохирол учруулдаг халдварт, паразитгах өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж мал, амьтны өвчлөл, халдварын хэмжээг аюулгүй түвшинд хүргэх, улмаар Монгол Улсын экспортын боломжийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

4.Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлж байна.

а/хилийн мал эмнэлгийн хорио цээрийн найдвартай хамгаалалт бий болгож, мал, амьтны халдварт өвчин, ялангуяа гоц халдварт өвчин улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх;

б/мал, амьтны халдварт өвчин илэрсэн, дамжин орж ирсэн нөхцөлд тэдгээртэй тэмцэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх бэлэн байдлыг мал эмнэлгийн албаны бүх шатанд бататгах, мал эмнэлгийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлийн хангамж, нөөцийг сайжруулах;

в/мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, халдвар судлал, ариун цэврийн магадлан шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний мал эмнэлгийн албыг олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх;

г/мал эмнэлгийн үйлчилгээг хувийн хэвшлийн нэгжүүдээр гүйцэтгүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, энэ чиглэлийн нэгжүүдийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

д/мал эмнэлгийн улсын хяналтын тогтолцоог боловсронгуй болгон, бүх шатанд бэхжүүлэх, үйл ажиллагааг нь жигдрүүлэх;

е/нийгэм эдийн засгийн хөгжилд ноцтой хор хохирол учруулдаг халдварт өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх.

Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

5.Хөтөлбөрийн зорилтыг дараахь арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

1/Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам:

а/хяналтад байх мал, амьтны өвчнийг бүртгэж, мэдээлэх, тэдгээртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг өвчин тус бүрээр гаргаж, шаардагдах зардал, нөхөн олговрыг санхүүжүүлэх эрх зүйн үндэс бүрүүлэх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх;

б/мал эмнэлгийн оношилгоо, судалгаа, мэдээллийн ажлыг Мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх үндсэн дээр үхрийн шүлхий, цээж, бог малын цэцэг зэрэг “а” ангиллын өвчнүүдээр манай улс бүрэн тайван болохыг олон улсын түвшинд баталгаажуулах;

в/мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр дамжин импортлогдож болох өвчнүүдийн жагсаалтыг гаргаж, нийтэд зарлан тодорхой бүс нутгийг хамруулан эдгээр өвчний талаар эрсдэлийн үнэлгээ хийж аюулгүй түвшинд байгаа тохиолдолд импортын зөвшөөрөл олгодог журам тогтоох;

г/эдийн засаг, худалдаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжиж буй орнуудтай мал эмнэлгийн хорио цээр, ариун цэврийн салбарт хамтран ажиллах талаар Засгийн газар болон мэргэжлийн байгууллага хооронд гэрээ, хэлэлцээр байгуулах;

д/шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр мал эмнэлэг, ариун цэврийн чиглэлээр сүүлийн жилүүдэд гүйцэтгэсэн шинжлэх ухаан, технологийн төслүүд, тэдгээрийн хүрээнд бий болгосон эм бэлдмэл, вакцин, оношлуур, багаж хэрэгсэл зэргийн ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлэх, энэ талаар цаашид баримтлах бодлого, чиглэл, төслийн талаар шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;

е/хөтөлбөрийн удирдлага, зохицуулалт, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах.

2/Гэгээрлийн яам:

а/мал аж ахуйн салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог нийгэм, үйлдвэрлэлийн эрэлт, шаардлагад нийцүүлэн өөрчлөх, мэргэжилтнүүдийг хөгжингүй орнуудад сургаж бэлтгэх, чадваржуулах, хүний нөөцийн ашиглалтыг сайжруулах;

б/мал аж ахуйн мэргэжилтэн менежер бэлтгэх сургуулиудын сургалтын агуулгад олон улсын байгууллагаас батлан гаргасан шинжлэх ухааны ололт, чиглэлийг тусгах замаар сургалтыг олон улсын түвшинд хүргэх;

в/мал сүргийг эрүүлжүүлэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, оношилгоо, шинжилгээний аргыг боловсронгуй болгох чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх;

3/Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам:

а/мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс сэргийлэх, хүн, мал, амьтдыг эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн болон мал эмнэлгийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;

б/Монгол Улсад бүртгэгдсэн хүн, мал, амьтны нийтлэг халдварт өвчнүүдийн халдварын тархалтын хяналт, судалгааны тогтолцоог бий болгох, мал, амьтнаас халдварладаг өвчнөөс өөрийгөө болон үр хүүхдээ хамгаалах арга ажиллагаанд хүн амыг сургах ажлыг өргөн далайцтай явуулах.

4/Сангийн яам:

-малын халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх зорилгоор жил бүрийн төсөвт тусгаж байгаа зардлыг нэмэгдүүлэхийн дээр энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, арга хэмжээг дунд болон урт хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, жил бүрийн төсөвт тусгах, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх.

5/Батлан хамгаалах яам:

а/мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед хорио цээр тогтоох, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх операттив төлөвлөгөөг Иргэний хамгаалалтын газар дээр боловсруулж, жил бүр тодотгол хийж байх;

б/аймаг, нийслэлийн иргэний хамгаалалтын нарийн мэргэжлийн хөдөлгөөнт отрядуудад дайчлан ажиллуулах мэргэжлийн хүмүүс, техник хэрэгслийн судалгаа, бүртгэлийг гаргаж жил бүр шинэчлэн тодотгож байх, мэргэжлийн хүмүүсийг

болзошгүй гамшгийн үед ажиллах дадлага, чадвар эзэмшүүлэх сургалтыг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх.

6/Хөдөө аж ахуйн улсын хяналтын байгууллага:

а/хилийн боомтууд дээр амьд мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг хорио цээрт оруулан саатуулах, ариутгах болон халдваргүйжүүлэлт хийх байгууламжийг барих, хил, гүний хяналтын улсын байцаагч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тэдний ажлын байрны нөхцөлийг сайжруулах талаар тусгай төсөл боловсруулж хэрэгжүүлэх;

б/мал эмнэлгийн эм бэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд тавих улсын хяналтыг хүчтэй болгож, эм бэлдмэл шалгах байгууллагын хүчин чадлыг нь нэмэгдүүлэх.

7/Хөдөө аж ахуйн хэрэгжүүлэгч агентлаг:

а/малын бруцеллез, ям, сүрьеэ, лейкоз өвчний тархалтыг аж ахуйн нэгж, хот айлын түвшинд нарийвчлан тогтоох, эрүүлжүүлэх арга хэмжээний дунд, урт хугацааны төсөл боловсруулж хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагуудтай хамтран хөрөнгийн эх үүсвэр олж хэрэгжүүлэх;

б/адууны ям өвчин олон жил илрээгүй, мэдээлэгдэхгүй багаа аймгуудад улсын комисс томилон ажиллуулж, эрүүлжилтийг баталгаажуулах, өвчний голомт хадгалагдсаар байгаа аймгийн адууг ям өвчнөөс эрүүлжүүлэхийн зэрэгцээ адууны халдварт цус багасах өвчинтэй тэмцэх арга хэмжээний төсөл боловсруулж хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

в/мал, амьтанд тохиолдож байгаа вирус, микоплазм, риккетси, бактери, мөөгөнцөрөөр үүсдэг өвчнүүд, цусны паразиттах болон цус сорогч үе хөлтнөөр дамжин халдварладаг өвчнийг бүрэн оношилж, бүртгэх, тархалтыг тогтоох, мэдээллийн сүлжээ буй болгох арга хэмжээ авах;

г/мал эмнэлгийн лабораторийн нэгдсэн сүлжээг бэхжүүлж, шуурхай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, гоц халдварт, экзотик, зооантропоноз өвчнүүдийг оношлох, сэргийлэх чадварыг нэмэгдүүлэх;

д/төв, орон нутгийн мал эмнэлгийн албадын бүтэц, тогтолцоог зах зээлийн нөхцөлтэй уялдуулан оновчтой, шуурхай байхаар зохион байгуулан бэхжүүлэх;

е/мал эмнэлгийн эм бэлдмэл, багаж, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг дэмжих, одоо ажиллаж байгаа үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчлэх дэмжлэг үзүүлэх, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл, багажийн нийлүүлэлт, борлуулалтыг сайжруулах;

ж/гахай, шувуу зэрэг суурин мал аж ахуйн цогцолбор, гоц халдварт өвчний голомт бүхий газрууд, стратегийн ач холбогдол бүхий цэгт хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх болон үхсэн мал, амьтныг устгах байгууламжуудыг нэгдсэн зураг төслийн дагуу бариулах ажлыг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

8/Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга:

Нутаг дэвсгэртээ энэхүү хөтөлбөрийн хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/малын эрүүл мэнд дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

б/мал эмнэлгийн хяналт, үйлчилгээний нэгжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг хэрэглэгчид ойртуулах, жигдрүүлэх, үнэлж дүгнэх, гүйцэтгэл хяналт тавих;

в/мал сүргийг бруцеллөз, сүрьеэ, ям, лейкоз, адууны халдварт цус багадах өвчнөөс эрүүлжүүлэх, халдварлалтын түвшинг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

г/мал сүрэгт өргөн тархсан, хохирол ихтэй халдварт, паразиттах өвчнөөс сэргийлэх талаар оновчтой арга хэмжээ авах замаар мал аж ахуйд учруулж буй хохирлыг багасгах;

д/малын гоц халдварт, халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг сум, дүүргийн төсөвт тусгаж санхүүжүүлэх;

е/мал эмнэлгийн байгууллагыг бэхжүүлэхэд дотоодын санхүүгийн эх үүсвэр гаргаж төсөл хэрэгжүүлэх, гадаад орон, байгууллагатай төслийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

ж/аймгийн онцгой комиссын төсөв, хийх ажлын чиглэлд мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх зардал, болзошгүй тохиолдолд шуурхай ажиллах арга хэмжээг тодорхой тусгах, иргэний хамгаалалтын мэргэжлийн бүлгийн бэлэн байдлыг хангуулах;

з/мал, амьтнаас хүнд халдварладаг өвчнөөс хамгаалах арга ажиллагаанд хүн амыг сургах ажлыг өргөн далайцтай явуулах.

9/Төрийн бус байгууллага:

а/мал эмнэлгийн чиглэлээр дотоод, гаададад мэргэжилтэн сургахад туслалцаа үзүүлэх;

б/малын эмч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлэх, тэднийг шинжлэх ухааны орчин үеийн мэдээллээр шуурхай хангах, ёс зүйн байдал, мэргэжлийн чадавхийг үнэлж дүгнэх асуудлыг хэрэгжүүлэх.

10/Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж:

а/мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага, иргэдтэй байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлэх;

б/малын эм, биобэлдмэл, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох арга хэмжээг хэрэгжүүлэх.

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6.Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй Үндэсний хөтөлбөрийн зөвлөл ажиллана. Зөвлөл нь орон тооны бус байна.

7.Хөтөлбөрийн зөвлөл нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих, дүгнэлт гаргах;

б/хөтөлбөрт өөрчлөлт, тодотгол хийх саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх.

в/Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээтэй холбогдох асуудлыг Засгийн газар болон холбогдох яам, агентлагуудад тавьж шийдвэрлүүлэх.

8.Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулах, хяналт тавих үүрэгтэй аймаг, нийслэлийн салбар зөвлөл ажиллана. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажлын чиг үүргийг Засаг дарга батална.

9. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж зохион байгуулах, сургалт, сурталчилгаа явуулах үүргийг Хөдөө аж ахуйн газар хариуцна.

10. Хөтөлбөрийн зөвлөл болон орон нутаг дахь салбар зөвлөл нь ажлаа жилээр төлөвлөн хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн зөвлөл жил бүрийн 4 дүгээр улиралд Хөтөлбөрийн зөвлөлд, Хөтөлбөрийн зөвлөл нь дараа оны 1 дүгээр улиралд Засгийн газарт тус тус тайлагнаж байна.

11. Үндэсний хөтөлбөрийн биелэлт, үр дүнг хөтөлбөрийн нэгдүгээр хавсралтад заасан хугацаа, шалгуур үзүүлэлтээр Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам хариуцан дүгнэж байна.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

12. Хөтөлбөрийг дор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:
а/ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс жил бүр олгох хөрөнгө;
б/ гадаадын хөрөнгө оруулалт;
в/ хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж;
г/ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;
д/ шинжлэх ухаан, технологийн сан;
е/ иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, сангийн хандив, тусламж, үйлчилгээний төлбөр.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

13. Хөтөлбөрийг 1999-2010 оны хугацаанд 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг жил бүр дүгнэхдээ дараахь шалгуур үзүүлэлтүүдийг баримтлан дүгнэнэ:

Нэгдүгээр үе шат - 1999-2000 оныг хамруулна. Энэ үе шатанд шаардлагатай хууль эрхийн актуудыг боловсруулан батлуулж, мал эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно. Сум, дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагуудыг хувийн хэвшилд бүрэн шилжүүлэх, материаллаг баазыг нь бэхжүүлэх арга хэмжээ авна.

Лабораторийн нэгдсэн сүлжээг бэхжүүлж, эпиемиологийн нэгжийн үйл ажиллагааг сэргээн хэвшүүлнэ. Мөн хөтөлбөрт тусгагдсан урт, дунд хугацааны зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд энэ хөтөлбөрийн 2 дугаар хавсралтад заасан төслүүдийн баримт бичгийг боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлсэн байна. Санхүүжүүлэх эх үүсвэр нь шийдэгдсэн төслүүдийг хэрэгжүүлж эхэлнэ.

Хоёрдугаар үе шат - 2000-2005 оныг хамруулна. Энэ үе шатанд бруцеллёз, сүрьеэ, ям, лейкоз, адууны халдварт цус багадах өвчний тархалтын байдлыг нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд тогтоож дуусна. Шүлхий, мялзан, цээж, бог малын цэцэг өвчнөөр бүрэн тайван статустай орны олон улсын жагсаалтад орсон байх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хилийн боомт дахь мал эмнэлгийн хорио цээрийн байгууламжуудыг тусгай зураг төслийн дагуу барьж дуусгана. Биоүйлдвэр, Малын эм бэлмдэл шалгах лабораторийг бэхжүүлэх төслийг хийж, санхүүжүүлэх үүсвэрийг олж, хэрэгжүүлэх арга хэмжээг эхлүүлнэ.

Гуравдугаар үе шат - 2005-2010 оныг хамруулна. Энэ үе шатанд бруцеллёз, сүрьеэ, ям, лейкоз, адууны халдварт цус багадах өвчний голомтыг устгах, дээрх өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Монгол Улсад тохиолдож байгаа бактер, мөөгөнцөр, риккетси, микоплазм, вирусын гаралтай өвчнүүд, цусны паразиттах болон цус сорогч үе хөлтнөөр дамжин халдварладаг өвчнийг бүрэн оношлон бүртгэж, эдгээр өвчнийг хянах, тэдгээртэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний стратегийг боловсруулна. Биоүйлдвэр, Малын эм бэлдмэл шалгах лабораторийг шинэчлэх ажлыг дуусгана. Мал эмнэлгийн лаборатори, хил, гүний хяналтын салбарт ажиллаж байгаа эмч нарыг нарийн мэргэжлийн дамжаагаар сургаж, мэргэшүүлсэн байна.

Найм. хөтөлбөрөөс гарах үр дүн

14.Ойрын /шууд/ үр дүн:

а/мал эмнэлгийн үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх эдийн засаг, эрх зүйн орчин бүрдэж, аж ахуйн талаар бие даан ажиллах боломж дээшилнэ;

б/мал эмнэлгийн хорио цээр, ариун цэврийн хяналтын бүтэц, зохион байгуулалт сайжирч, улмаар мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын түвшин дээшилнэ;

в/мал, амьтныг өвчнөөс урьчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх тогтолцоо боловсронгуй болно;

г/гадаад орноос мал, амьтны гоц халварт өвчин дамжин орж ирэхээс сэргийлэх эрх зүй, нийгэм, эдийн засгийн орчин бүрдэж, хилийн хорио цээр, ариун цэврийн хамгаалалт сайжирч, мал, амьтны гоц халдварт өвчнөөр тайван байгаа одоогийн түвшин баталгаажина;

д/мал сүргийг эрүүлжүүлэх ажлыг дэмжихэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн идэвхтэй оролцоо, хамтач ажиллагаа, зорилт, чиг үүрэг, хариуцлагын шинэ тогтолцоо бүрдэнэ.

15.Хэтийн /шууд бус/ үр дүн:

а/мал амьтнаас хүнд халдварлах өвчний тархалт хумагдаж , хүн амын эрүүл мэндэд таатай нөлөөлнө;

б/малын өвчлөл, ялангуяа ужиг халдварт болон паразиттах өвчний түвшин, тэдгээрээс үүдэн гарах хохирлын хэмжээ буурна;

в/мал эмнэлгийн ажил, үйлчилгээ гүйцэтгэх хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, үндэсний мал эмнэлгийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөх үнэлэмж дээшилнэ;

г/улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чухал түлхэц болж экспортын боломж дээшилнэ.

**ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ ХУГАЦАА,
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлтүүд	Дүгнэх хугацаа	Хэрэгжилтийг нотлох баримт
1.	Зах зээлийн эдийн засгийн орчин малын эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлгийн үйлчилгээ явуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. Үүнд: 1/малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулинд өөрчлөлт оруулах; 2/шаардлагаар нядалж буй мал, амьтдын үнийг нөхөн төлөх эрх зүйн асуудлыг шийдвэрлүүлэх; 3/бүртгэлтэй өвчний жагсаалт, тэдгээрийг мэдээлдэг журам; 4/хорио цээр, хязгаарлалт тогтоох журмыг шинэчлэх; 5/мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг импортлоход эрсдэлийн үнэлгээ хийх журам; 6/мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн хорио цээрийн хууль; 7/малын шилжилт хөдөлгөөнд хорио цээрийн хяналт тавих журам;	2001 он	Холбогдох хууль эрхийн баримт бичгүүд
2.	Мал эмнэлгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.	2001 он	Мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагыг бүрэн хувийн хэвшил шилжүүлж, мал эмнэлгийн хяналт, үйлчилгээг дагнасан бие даасан агентлагууд ажиллана.
3.	Мал эмнэлгийн лабораторийн нэгдсэн сүлжээ байгуулагдана.	2001 он	Лабораторийн 3 шаттай нэгдсэн тогтолцоо бий болж, зохих дүрэм, журам нь батлагдан, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.
4.	Хилийн боомт дахь мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын албыг уирлага, зохион байгуулалт, боловсон хүчин, материаллаг баазын талаар бэхжүүлсэн байна.	2001 он	Албаны бүтэц, зохион байгуулалт төгөлдөржиж, өндөр, мэдлэг чадвартай боловсон хүчнээр хангагдсан байна. Хилийн боомт ээр хорио цээрийн арга хэмжээ хэрэгжүүлэх байгууламжууд зохих ёсоор баригдсан байна.

5.	Малын бруцеллэз, ям, сүрьеэ, лейкоз, адууны халдварт цус багаах зэрэг өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, эхний шатны үр дүн гарна.	2005 он	Бруцеллэз, сүрьеэ, ям, адууны халдварт цус багадах, лейкоз зэрэг өвчний халдварлалтын байдлыг хот айл нэг бүрийн түвшинд албан ёсоор тогтоож, мал эмнэлгийн байгууллагын хяналтад бүртгэн авч, өвчний халдварлалттай хот айлыг эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна.
6.	Монгол Улс шүлхий, мялзан, цээж, бог малын цэцэг өвчнөөр тайван статустай орны Олон улсын жагсаалтад орсон байна.	2005 он	Олон улсын амьтны халдварт өвчний байгууллагаас гаргасан албан ёсны жагсаалтад орж дэлхий дахинд зарлагдсан байна.
7.	Бруцеллэз, ям, сүрьеэ, лейкоз, адууны халдварт цус багадах өвчний голомтуудыг устгах, мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2010 он	Өвчний голомт устсан, хот айл эрүүлжсэн тухай улсын комиссын дүгнэлт, баталгаа гарсан байна.
8.	Монгол оронд тохиолдож байгаа бактери, мөөгөнцөр, риккетси, микоплазм, вирусын гаралтай өвчнүүд, цусны паразитын болон цус сорогч үе хөлтнөөр дамжин халдварладаг өвчнүүдийг бүрэн оношлож, мал эмнэлгийн бүртгэл, хяналтад бүрэн авч тэмцэх, сэргийлэх арга хэмжээний стратегийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	2010 он	Өвчнүүдийг оношлож, бүртгэсэн тайлан, жагсаалт, тэмцэх, сэргийлэх арга хэмжээний стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга зам, заавар гарсан байна.
9.	Мал эмнэлгийн хүрээлэн, Биоүйлдвэр, Малын эм бэлдмэл шалгах Улсын нэгдсэн лаборатори, Хөдөө аж ахуйн их сургуулийн мал эмнэлгийн факультет зэрэгт их засвар өргөтгөл хийсэн байна.	2010 он	Хүрээлэн, сургууль, үйлдвэр, лабораторийн судалгаа, сургалт, техник, технологийн шинэчлэлт, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар дээшилсэн байна.
10.	Шинжлэх ухаан, технологийн сангийн шугамаар хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг гаргана.	2000 2005 2010	Үр дүнгийн эдийн засгийн үнэлгээ тогтоогдоно.

**“МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХИ САНАЛ**

№	Төслийн нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Шаардагдах хөрөнгө /тэрбум төгрөг/
1	Малын зооантропоноз өвчнүүдээс /бруцеллёз, ям, сүрьеэ, лейкоз, адууны халдварт цус багасах/ эрүүлжүүлэх, мал эмнэлгийн лабораторийн сүлжээг бэхжүүлэх төсөл	6 дэд төсөлтэй 2000-2010 он	12.0
2	Мал эмнэлгийн байгууллагын удирлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх, үйлчилгээг сайжруулах төсөл	1999-2010 он	3.6
3	Мал эмнэлгийн биобэлдмэл, эмийн үйлдвэрлэл, түүний хяналтыг хөгжүүлэх төсөл	2000-2005 он	4.0
4	Хилийн мал эмнэлгийн хорио цээрийн салбарыг бэхжүүлэх төсөл	1999-2002 он	0.140
5	Мал эмнэлгийн сургалт, эрдэм шинжилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл	2000-2010 он	1.0
Дүн			20.2

**“МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: - Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд
- Орлогч дарга: - Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга
- Гишүүд:
- Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Мэдээлэл,
Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга;
 - Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга;
 - Гэгээрлийн яамны Бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга;
 - Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага,
төлөвлөлтийн газрын дарга;
 - Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Хөтөлбөр,
төслийн хэрэгжилтийг зохицуулах албаны дарга;
 - Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн захирал;
 - Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Эрүүл
мэндийн сургалт боловсрол, урьдчилан сэргийлэх
вакцин, халдварт өвчний сэргийлэлтийн асуудал
хариуцсан мэргэжилтэн;
 - Хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны
Мал эмнэлгийн хяналтын улсын ерөнхий байцаагч;
 - Улсын Иргэний хамгаалалтын газрын хөдөө аж ахуй,
үйлдвэрийн хамгаалалт хариуцсан мэргэжилтэн.
- Нарийн бичгийн дарга: - Хөдөө аж ахуйн хэрэгжүүлэгч агентлагийн
Мал эмнэлгийн албаны дарга.